

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 29 өдөр

Дугаар: 13

Улаанбаатар хот

**Гэрээний загварт өөрчлөлт  
оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.6, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Малын индексжүүлсэн даатгалын гэрээний загвар”-ын 5.8 дахь хэсгийн “6 дугаар сарын 30-аас ” гэснийг “8 дугаар сарын 31-ээс” гэж, 6.3 дахь хэсгийн “6 дугаар сарын 30-аас” гэснийг “8 дугаар сарын 31-ээс” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮН, ХУРАЛ ДАРГАЛАГЧ****Ч.ТАВИНЖИЛ**